



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2021 оны 11 сарын 19 өдөр

Дугаар А/564

Арвайхээр

**Томилгоот нэгжийн бүрэлдэхүүний
сургалтыг зохион байгуулж явуулах
тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Орон нутгийн хамгаалалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.2, 11.3.3, 11.4.2, 11.6, 11.8, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 14.2.5 дахь заалтууд, Сангийн сайдын 2021 оны 61 дүгээр тушаалаар батлагдсан “Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам”-ыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Арвайхээр, Хархорин сумдын орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүнтэй явуулах сургалтыг 2021 оны 11 дүгээр сарын 19-20-ны өдрүүдэд Зэвсэгт хүчний 256 дугаар анги, Хархорин суманд байрлах Онцгой байдлын хэлтсийн сургалтын төвийн материаллаг баазыг тус тус түшиглэн 2 хоногийн хугацаатай зохион байгуулж явуулсугай.

2. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний сургалтад шаардагдах зардлын тооцоог хавсралтаар баталсугай.

3. Сургалт явуулахад шаардагдах 1.000.000 (нэг сая) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Ганболд)-д зөвшөөрсүгэй.

4. Орон нутгийн хамгаалалты томилгоот нэгжийн сургалтад оролцох бүрэлдэхүүний хувийн бэлтгэлийг хангуулж, тогтоосон хугацаанд Засаг даргын Тамгын газартаа бэлэн байлгахыг Арвайхээр, Хархорин сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Орон нутгийн хамгаалалтын томилгоот нэгжийн бүрэлдэхүүний сургалтыг зохион байгуулах үйл ажиллагаанд байнгын хяналт тавьж аюулгүй байдал, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Цэргийн штаб (хурандаа М.Дэлгэрсайхан)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011101198

Аймгийн Засаг даргын 2021 оны..11..
дугаар сарын .19...-ны өдрийн..А/564
дугаар захирамжийн хавсралт

ОРОН НУТГИЙН ХАМГААЛАЛТЫН ТОМИЛГООТ
БҮРЭЛДЭХҮҮНИЙ СУРГАЛТЫН ТӨСВИЙН ТООЦОО

№	Зардлын нэр	Зардлын тооцоо		
		Тоо	Нэг бүрийн дүн	Нийт дүн
1	Хоолны зардал	90 хүн	8500 төгрөг /өдөрт 1 удаа, 2 хоног/	765.000 төг
2	Хичээлийн хэрэглэл - бал - дэвтэр Батламж	50 ш 50 ш 50 ш	50x600=30.000төг 50x600=30.000төг 50x1500=30.000тө г	135.000 төгрөг
3	ШТМ, цахилгааны зардал	ДТ	20*2500	50.000 төгрөг 50.000 төгрөг Нийт: 100.000 төгрөг
Дүн		1.000.000 төгрөг		

-оОо-